

Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Хувийн удирдамж боллох Мормоны Ном

Бид хамгийн ихээр сүнсийг мэдрэх үед бүгд л гэртээ эргэн харьж, Бурхантай хамт амьдрах хүслээр дүүрдэг. Тэрээр замыг маань бэлтгэн, түүгээр хэрхэн дагахыг заах бидний Аврагч болох Хайрт Хүүгээ бидэнд бэлэг болгон өгсөн билээ. Тэрээр замыг маань чиглүүлэх бошиглогчдыг бидэнд өгсөн. Бошиглогч Иосеф Смит бошиглогчдын цэдгүүдийг орчуулах бурханлиг урмаар өдөөгдсөн бөгөөд энэ нь Мормоны Ном юм. Энэ нь биднийг Бурхан уруу аваачих зам дээрх баттай удирдамж болдог.

Энэхүү үнэт номын талаар Иосеф Смит “Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуурын чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүтэйгээр, түүний зааврыг мөрдсөнөөр л хүмүүн Бурханд илүү ойртох болой” гэжээ.¹

Мормоны Номон дахь сургаалууд нь Бурханы зарлигууд юм. Эдгээрийн зарим нь бид юу хийх ёстой болон хэн болох тухай Өөрийн бошиглогчдоор дамжуулан Аврагчаас шууд ирсэн тушаалууд байдаг. Мормоны Ном нь Түүнийг дагах зарлигт дуулгавартай байх бидний шийдвэр төгс байдал хийгээд итгэлийг өсгөх Аврагчийн жишээг багтаасан байдаг. Энэхүү ном нь биднийг удирдан чиглүүлэх Христийн

сургаалаар дүүрэн байдаг. 2 Нифай дахь жишээг дурдъя:

“[Есүс] хүмүүний үрст: Та нар намайг дагагтун хэмээсэн бөлгөө. Иймийн тул, хайрт ах дүү нар минь, бид Эцэгийн зарлигуудыг сахихдаа бэлэн байхаас бусдаар бид Есүсийг дагаж чадах уу?”

“Мөн Эцэг хэлэхдээ: Наманчил та нар, наманчил та нар, мөн миний Хайрлагдсан Хүүгийн нэрээр баптисм хүртэгтүн” гэжээ (2-р Нифай 31:10–11).

Нарийн бөгөөд шулуун зам дээр үлдэхэд минь туслах галын баптисм болох Ариун Сүнсийг бид хүлээн авах ёстойг энэ номонд тодорхой заажээ. Эцэж цуцалгүйгээр Христийн нэрээр үргэлж залбирах ёстой хэмээн бидэнд заасан бөгөөд хэрэв үүнийг хийвэл бидэнд дараах амлалт өгөгджээ: “Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно” (2 Нифай 31:20).

Мормоны Номон дахь Бенжамин хааны гайхамшигт номлолд Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайр нь ямар утга учиртай болохыг тодорхой өгүүлдэг.

Цагаатгалын хүчээр бидний мөн чанар өөрчлөгдөн, зарлигуудад чин сэтгэлээсээ дуулгавартай байхын хэрээр бид Бурханы хайраар дүүрэн байх болно (Мозая 4:1–12-г үз).

Мөн Мормоны Ном бидэнд энэ амьдралдаа хилэнцийг үйлдэх хүсэлгүй тийм их цэвэр ариун болж чадна хэмээх итгэл найдварыг өгдөг (Мозая 5:2)-г үз. Сатан амьдралын турш итгэлийг минь алдруулж, уруу татахыг оролдох үед энэ найдвар нь зориг болон тайвшралыг бидэнд өгдөг.

Би цөөхөн мөрийг ч болов Мормоны Номноос унших бүрт энэ ном үнэн бөгөөд Есүс бол Христ, бид Түүнийг дагаснаар Бурхандаа эргэн очиж чадах бөгөөд хайртай хүмүүсээ гэр уруугаа авч явж чадна хэмээх гэрчлэл маань өсөхийг мэдэрдэг. Миний хувьд энэ ном хамгийн шилдэг нь байсаар ирсэн. Энэ бол Бурханы үг юм.

Бид болон бидний хайртай хүмүүс үүнээс өдөр бүр шимтэн судлаасай хэмээн би залбирч байна. Энэ нь жинхэнэ үнэн удирдамж гэдгийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна.

ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 64.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Бид судрууд болон хожмын үеийн бошиглогчдын үгсийг сургаалынхаа эх сурвалж болгон ашиглах үед Сүнс бидний гэрч болдог. Биднийг заах үед энэ нь ‘хүмүүнийг итгүүлэх Бурханы хүч’-ийг авчирдаг (С ба Г 11:21)” *Teaching, No Greater Call* [1999], 51). Уншихдаа Ерөнхийлөгч Айрингийн захиас бичгийн гол санаа, Иосеф Смитийн Мормоны Номын талаар хэлсэн мэдэгдлийн талаар тунгаан бод. Гэр бүлийнхнээсээ Мормоны Номон дахь сургаалуудын дагуу амьдрах нь тэдэнд хэрхэн Бурхантай илүү ойр байхад тусалсан тухай хуваалцахыг хүс.

“Суралцагсад нь судрууд дээрх зарчмуудыг харилцан ярилцсанаар тэд хувиараа судраас суралцахад шаардагдах ур чадвараа хөгжүүлдэг” (*Teaching, No Greater Call*, 54). Захиас бичигт орсон судруудыг уншин, зааж буй зарчмуудыг нь олж харилцан ярилц.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Миний эрхэмлэх Мормоны Ном

Хиллари Холбрук

2005 оны 8-р сард, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Сүмийн гишүүдийг Мормоны Номоо он дуусахаас өмнө уншиж дуусгахыг уриалсан тэр үед би номоо бүхэлд нь уншина гэж өөртөө амласан юм. Би хэдийгээр Мормоны Номон дахь түүхүүдийг мэддэг байсан ч номыг бүхэлд нь хэзээ ч уншиж байсангүй. Одоо би амлалтаа биелүүлэх хэрэгтэй.

Би судруудыг амьдралдаа хэрэгжүүлж, тэдгээрийг өөрийн болгох тухай заалгасан байлаа. Тиймээс би уншиж байхдаа хуудасны хажуугийн зайнд уг хэсгийн гол санааг бичиж байв. Би мөн чухал газрыг үзүүлэхийн тулд давтагдсан үг, хэллэгүүдийн доогуур зурж, тэмдэглэж байв.

Би Бурханы бусдад хэлсэн үг мөн надад хэлсэн үг гэдгийг санаж байхын тулд судар дээрх нэрсийн хажууд өөрийн нэрийг бичив. Жишээ нь, 2 Нифай 2:28-д би өөрийн нэрийг: “Мөн эдүгээ, [Хиллари] минь, агуу их Зуучид найдан, мөн түүний агуу зарлигуудыг анхаараасай хэмээнэ би” гэж бичив. Мормоны Номыг өөрийн болгох тусам би өдөр бүр илүү ихээр сэтгэл догдлон уншдаг болов.

Өдөр бүр уншихын хэрээр, залбирлууд маань чин сэтгэлийн, амин хувийн болов. Мөн би хичээлдээ илүү анхаарч, бусадтай нөхөрлөх Сүнсний өдөөлтийг дагадаг байв. Жилийн хамгийн сүүлийн орой би Мормоны Номыг уншиж дуусгалаа.

Би дараа нь Мормоны Ном болон бусад судруудыг уншихын чухлыг ойлгосон бөгөөд амьдралдаа илүү олон удаа уншихыг хүссэн.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Гэртээ харихад минь туслах хөтөч

Та нарт төөрөөд гэртээ харих замаа мэдэхгүй үед ямар байх бол? Хэрэв замыг тань заах хэн нэгнийг дагах боломжтой болбол та нар баярлах уу? Мормоны

Ном бол Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиход маань туслах хөтөчтэй адил гэж Ерөнхийлөгч Айринг хэлж байна.

Мормоны Номны бидэнд хэлдэг гэртээ харихын тулд бидний хийх шаардлагатай зарим жишээ дор байна. 2 Нифай 31:10, 11, 20-г унш. Доорх хэллэг бүрийн доогуур зурж, Мормоны Номны зөв мөрийг

бич. Та нар аль нэг хэллэгийг хоёр дахин ашиглах хэрэгтэй болно.

Наманчил мөн баптисм хүрт.

Найдварын төгс гэрэлтэй бай.

Бурханыг болон бүх хүмүүнийг хайрла.

Есүсийг дага.



Итгэл • Гэр бүл • Халамж

Өсвөр үеийг халамжлах нь бидний үүрэг мөн

Энэ материалыг судалж, айлчлан очсон эгч нарт аль болох тохиромжтойгоор харилцан ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Судруудаас: Сургаалт Үгс 22:6; Ефес 6:4; Инос 1:1; Алма 53:20–21; 56:47; 57:27

Халамжлан асрахгүй бол өсвөр үеийнхэн маань Мозая 26-д тайлбарласны адил аюулд унах болно. Олон залуус эцгүүдийнхээ уламжлалд итгэдэггүй. Тэд итгэлийн хувьд тусгаар хүмүүс болж, тэр чигээр үддэг. Хэрэв өсвөр үеийнхэн маань Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх өөрсдийн үүргийг ойлгохгүй бол ийм маягаар холдон явах болно.

Тиймээс өсвөр үеийнхнийг маань юу аюулгүй авч үлдэх вэ? Сүмд бид авралын зарчмууд болох гэр бүлийн зарчмуудыг, өсвөр үеийхэнд гэр бүлээ бүрдүүрэхэд туслах зарчмуудыг, тухайн бүрдсэн гэр бүлд заах, тэдгээр гэр бүлүүдийг ёслолууд болон гэрээнүүдэд бэлтгэх мөн хойч үедээ үргэлжлүүлэн заах зарчмуудыг заадаг.

Эцэг эх, удирдагчид болон сүмийн гишүүдийн хувьд бид энэ үеийг Абрахамын болон ариун сүмийн адислалуудад бэлтгэж байгаа билээ. Бид гэр бүлийн тунхагт заасан сургаалын гол зарчмуудыг маш тодорхой заах үүрэгтэй. Эцэг, эх байх нь мөнхийн үүрэг, хариуцлага мөн. Төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүн бүр өөрсдийн үүрэгтэй байдаг.

Бид энэхүү сургаалыг ямар

ч хэлбэрээр зааж болно. Бид гэрлэлт болон гэр бүлийн талаар ярихдаа хүндэтгэлтэй хандах ёстой. Өсвөр үеийнхэн маань гэр бүлийн талаарх агуу найдвар, ойлголтыг зөвхөн бидний үг ярианаас биш, гэр бүлтэй холбоотой зөв зарчмуудын үлгэр жишээнээс олж авдаг.

Жюли Б.Бек, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч.

Бидний түүхээс

1995 оны 9-р сарын 23-ны өдрийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий цуглаан дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли эгч нарт хандан хэлэхдээ: “Бидний амьдрач буй дэлхий нь хүндэтгэх зүйлсийг маань үгүйсгэсэн, эмх замбараагүй дэлхий юм. Сэтгэл өвдмөөр дуу хоолой удаан хугацаанд заншил болон тогтсон зан төлөвийн жишгүүдээс урван тэрслэхийг уриалан дуудаж байна”¹ гэжээ. Ерөнхийлөгч Хинкли цааш нь эгч нарт, сүмд болон газар бүрийн хүмүүст “Тэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” -ийг танилцуулсан.

Өнгөрсөн жилүүдэд бошиглолын энэ баримт бичиг олон хэл дээр орчуулагдан дэлхийн удирдагч нарт хүргэгджээ. Тунхаг нь “нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийг хамгаалан, бэхжүүлэхэд туслан дэмжих”-ийг иргэд болон төр, засгийн удирдагчдаас хүсдэг.²

Энэхүү тунхаг Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд гэр бүлийн талаарх итгэлийн үндэс суурь, чанд мөрдөх тунхаглал болсон бөгөөд эдгээр заавруудын дагуу амьдарснаар бид гэр бүлээ хүчирхэгжүүлэн бат бөх байлгаж чадна гэдгийг мэднэ.

Эшлэл

1. Гордон Б.Хинкли, “Stand Strong Against the Wiles of the World,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 99.
2. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиахона*, 2004 оны 10-р сар, 49-г үз.

Би юу хийж чадах вэ?

1. Би эгч нарт “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг ашиглан өсвөр үеийнхнийг халамжлан хүмүүжүүлэхэд нь хэрхэн тусалж чадах вэ? Тунхаг бичгээс хуваалцан, эгч нарт гол сургаалуудыг илүү сайн заасан хэсгүүдийг олж, тэмдэглэхэд нь тусалж болно.

2. Өсвөр үеийнхнийг би хэрхэн халамжлах вэ? Та нарын анхаарал халамж хэрэгтэй тойрог, салбар, гэр бүлийн гишүүн эсвэл хамт олны нэгийг олох талаар тунгаан бодож болох юм.

Нэмэлт мэдээллийг www.relief-society.lds.org-оос үз.